



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/272

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 25.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод аврах ажиллагааг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, ангийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн шуурхай удирдлагын газар (онцгой байдлын хурандаа Б.Мандахгэрэл)-т даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ




Т.БАДРАЛ

0004313

D:\My Documents\Blank\2015-tushaal

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
А/272... дүгээр тушаалын хавсралт



УУРХАЙ, УУЛЫН ҮЙЛДВЭР, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЮУЛТАЙ ОБЪЕКТОД
АВРАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

ГАРЧИГ

1. Нийтлэг үндэслэл
2. Аврах ажиллагааны зохион байгуулалт
3. Аюул ослын эхний үе шатанд гүйцэтгэх зохион байгуулалтын ажиллагаа
4. Аврах ажиллагааны үед холбоо зохион байгуулах
5. Аюул ослын үед тусгай мэргэжлийн албадыг зохион байгуулж ажиллуулах
6. Аврах бүлгийн шуурхай ажиллагаа
7. Өндөр халуунтай нөхцөлд аврах ажиллагаа явуулах
8. Газрын дор гал түймэр унтраах
9. Аврах ажиллагааны үед Уул уурхайн аврах ангийн албан хаагчийн үүрэг

ХАВСРАЛТУУД

- 1 дүгээр хавсралт. Ослын дуудлагын хуудас
- 2 дугаар хавсралт. Шуурхай ажиллагааны бүртгэлийн дэвтэр
- 3 дугаар хавсралт. Шуурхай ажиллагааны төлөвлөгөө
- 4 дүгээр хавсралт. Бүлгийн аврагчдын биедээ нэмэлтээр авч явах багаж, хэрэгслийн жагсаалт
- 5 дугаар хавсралт. Өндөр халуунтай нөхцөл, хязгаарлагдмал орчинд аврагчдын тусгаарлагч шүүгч багтай ажиллах хугацаа
- 6 дугаар хавсралт. Уул уурхайн аврах ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объект*, үзэгдэх орчингүй, агааргүй, хорт хийтэй, хязгаарлагдмал орчинд аврах ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Тухайн объектод гамшиг, аюул, ослын үед аврах ажиллагааг үр дүнтэй, шуурхай зохион байгуулахад энэ журмын зорилго оршино.

1.3. Журмыг хэрэгжүүлэхдээ Гамшгаас хамгаалах тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Хүдэр, хүдрийн бус, шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Баяжуулах үйлдвэр, нүүрс бутлан ачих технологи дамжлагын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Уул уурхайн аврах ангийн дүрэм, Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам, Гал түймэр унтраах дүрэм, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм” болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Аврах ажиллагааны зохион байгуулалт

2.1. Ослын үеийн удирдагчаар тухайн уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ерөнхий инженер ажиллах бөгөөд түүний эзгүйд диспетчер уг үүргийг түр гүйцэтгэнэ. Ослын үеийн удирдагчийн гаргасан шийдвэрийг тухайн объектийн ажилтнууд болон аврах ажиллагаанд оролцож буй албан хаагчид заавал биелүүлнэ.

2.2. Аврах ажиллагааны ерөнхий удирдагчаар төв, орон нутгийн Онцгой байдлын газар, Аврах тусгай болон Уул уурхайн аврах ангиас шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй томилогдсон албан хаагч ажиллана.

2.3. Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулж даалгаврыг Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагчид бичгээр өгнө. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч, Ослын үеийн удирдагч нарын санал зөрсөн тохиолдолд Ослын үеийн удирдагчийн шийдвэрийг баримтална. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч “Шуурхай ажиллагааны дэвтэр”-т өөрийн саналаа бичнэ.

2.4. Ослын үеийн удирдагч аврах ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:

2.4.1. эхний ээлжинд уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ;

2.4.2. аюул ослыг арилгах үр дүнтэй аргыг тодорхойлох;

2.4.3. аюул ослын голомт дээр шаардлагатай хүч хэрэгслийг төвлөрүүлэх, зөв хуваарилах;

2.4.4. аврах ажиллагаа явуулж байгаа газартай тасралтгүй холбоотой байж, нөхцөл байдлыг тодруулж, шуурхай удирдлагаар хангах;

2.4.5. шуурхай ажиллагааны биелэлтийг хангах.

2.5. Аюул, ослын үед уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, ажиллагсдын аюулгүй газарт очих зам, үйл ажиллагааг “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-өөр тодорхойлно.

2.6. Газрын дор болон үзэгдэх орчингүй, хязгаарлагдмал, агааргүй, хорт хийтэй орчинд аврах ажиллагаа явуулахдаа тусгаарлагч шүүгч багтай 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй бүлгийг ажиллуулна. Аврагчид нь зөвхөн нэг бүлгийн аврагчид байна.

2.7. Тусгаарлагч шүүгч багтай ажиллах албан хаагч нь эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан, сургалтад хамрагдаж баг эзэмших эрх авсан байна. Багтай ажиллах эрхгүй албан хаагчийг агааргүй орчинд ажиллуулахыг хориглоно.

2.8. Тусгаарлагч шүүгч багтай аврагчдын ээлжинд ажиллах хугацаа нь багны хүчин чадлаас шалтгаалах ба цэвэр агааргүй орчинд 4 цагаас хэтэрч болохгүй.

2.9. Ослын үеийн удирдагч эхний ээлжинд “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ба үүнтэй хамт уурхайгаас гараагүй хүний тоо, агааргүй орчинд байж болох хүний байрлал, нөхцөл байдал, агааржуулалтын горим, аюулын бүс зэргийг тодорхойлно.

2.10. Ослын үеийн удирдагч аврах ажиллагааны удирдагчид үүрэг өгөхдөө дараах мэдээллээр хангасан байна:

2.10.1. аюул ослын төрөл, болсон газар, үүссэн цаг хугацаа, өртсөн бүс;

2.10.2. өртсөн хүний тоо, тэдний байж болох байрлал;

2.10.3. агаарын урсгалын чиглэл, аюулын бүсэд өгч буй агаарын хэмжээ;

2.10.4. уул уурхайн аврах ангийг ирэхээс өмнө авсан арга хэмжээ, хүрсэн үр дүн;

2.10.5. аврах бүлгийн явах чиглэл, замын малталтын нөхцөл байдал;

2.10.6. уурхайн малталтад байгаа аюул осол арилгах зориулалттай тоног төхөөрөмжийн байршил.

2.11. Аюул ослын төрөл, хаана үүссэн талаар бодит мэдээлэл байхгүй тохиолдолд зөвхөн нэрвэгдэгсдийг аврах ажлыг гүйцэтгэх ба зэрэгцэн нөхцөл байдлыг тодруулах хайгуулын ажиллагааг зохион байгуулна.

2.12. Ослын үеийн удирдагч Уул уурхайн аврах ангийн бие бүрэлдэхүүнд аврах ажиллагааны удирдагчаар дамжуулан үүрэг даалгаврыг өгнө. Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ажилтнуудыг аюул ослын бүсэд ажиллуулахдаа аврах ажиллагааны ерөнхий удирдагчтай зөвшилцөнө.

2.13. Ослын газарт очсон удирдах албан тушаалтан аюул ослын нөхцөл байдалтай танилцаж, аврах ажиллагааны удирдлагыг албан ёсоор аваагүй тохиолдолд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар зөвхөн санал гаргаж Шуурхай ажиллагааны дэвтэрт бичнэ.

2.14. Хэрвээ “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж дууссан, хэрэгжүүлэх явцад үр дүн гарахгүй нь тодорхой болсон, аюулын нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө” (3 дугаар хавсралт) боловсруулна. Уг төлөвлөгөөг Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар батална.

2.15. “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө” ба “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй гэнэтийн шийдвэрийг Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар зөвшилцөн гаргаж энэ тухай шуурхай ажиллагааны дэвтэрт бичиж, хэрэгжүүлнэ.

2.16. Аврах ажиллагаа явуулж байгаа бүх тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

2.17. Аврах ажиллагааны үр дүнг тодорхойлох, аврагчдын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар ажиллагаа явуулж байгаа газарт байнга орж танилцах үүрэгтэй.

2.18. Аюул ослын голомт дээр нөхцөл байдал гэнэт өөрчлөгдсөн тохиолдолд (тэсрэмтгий хий их хэмжээгээр ялгарсан г.м) аврах бүлгийн дарга шийдвэр гаргах ба энэ тухай газрын гүний удирдлагын төвд яаралтай мэдэгдэнэ.

2.19. Аврах ажиллагааны удирдагч нэрвэгдэгсдийн амь насыг аврахтай холбоотой хойшлуулшгүй ажлын үед аврагчдад тохиолдож болзошгүй эрсдэлийг зөв тооцож, ажиллагааг шуурхай удирдана.

Гурав. Аюул ослын эхний үе шатанд гүйцэтгэх зохион байгуулалтын ажиллагаа

3.1. Аюул ослын тухай анхны мэдээллийг тухайн уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн диспетчер хүлээн авна. Мэдээллийг хүлээн авмагц “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу ажиллана.

3.2. Уул уурхайн аврах ангийн дуудлага хүлээн авагч дуудлагаар эхний ээлжинд “Түгшүүр” дохиог зарлаж жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүнд мэдэгдээд “Ослын дуудлагын хуудас”-ыг 2 хувь хөтөлнө. (1 дүгээр хавсралт) Эхний дуудлагаар гарч буй бүлэг “Ослын дуудлагын хуудас” болон тухайн уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г авч явна.

3.3. Ослын үеийн удирдагч Уул уурхайн аврах ангийн эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчид үүссэн нөхцөл байдлын тухай танилцуулж даалгаврыг бичгээр өгнө. Аюул ослын нөхцөл байдал, шуурхай бүлэгт өгсөн даалгаврын агуулга, аврах бүлгийн ослын голомтод ажилласан цаг, удирдагчийн гаргасан шийдвэрийн тухай Шуурхай ажиллагааны дэвтэрт тухай бүрт тэмдэглэнэ. Мөн холбогдох зураг, схем, төлөвлөгөөг хавсаргана. (2 дугаар хавсралт)

3.4. Эрэн хайх аврах ажиллагааны удирдагч даалгаврыг хүлээж аваад бүлгийн аврагчдад үүссэн нөхцөл байдал, шуурхай ажиллагааны даалгаврыг танилцуулж уурхайн малталтын зураглал, явах зам, агааржуулалтын схем, үүссэн нөхцөл байдал, аврагчдын гүйцэтгэх үүрэг, ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийг зааж бүлгийг ажилд оруулна.

3.5. Аврах ажиллагааг шуурхай удирдахын тулд газрын дээрх болон газрын гүний удирдлагын төвийг байгуулна. Газрын гүний удирдлагын төв нь аюул осол болсон газартай аль болох ойролцоо цэвэр агаарын урсгалд байрлаж ажиллагааг шуурхай удирдлагаар хангах ба бэлтгэл бүлэг, шаардлагатай тоног төхөөрөмж тэнд байрлана.

3.6. Газрын гүний удирдлагын төв дээр аврах ажиллагааны удирдагчаар Уул уурхайн аврах ангийн ерөнхий инженер, салбарын захирагч нар ажиллана.

Дөрөв. Аврах ажиллагааны үед холбоо зохион байгуулах

4.1. Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн диспетчер Уул уурхайн аврах ангийн дуудлага хүлээн авагчтай шууд холбогдох боломжтой байна.

4.2. Аюул ослын үед аврах ажиллагааны удирдагчаас аврах бүлэг хүртэл шууд холбоог зохион байгуулна. Холбооны хэрэгсэлд дуут, гэрлэн, утсан холбоо, аврах ажлын утастай ба утасгүй холбоо багтана.

4.3. Агааргүй, үзэгдэх орчингүй нөхцөлд аврагчид дараах дуут дохиог хэрэглэнэ. Үүнд:

Нэг дохио- Зогс (хөдөлгөөний үед), ажлаа зогсоо;

Хоёр дохио – Ухар;

Гурван дохио – Урагшаа, ажлаа үргэлжлүүл;

Дөрвөн дохио – Аюулаас холд;

Таван дохио – Ажилд туслаач;

Олон давтсан дохио – Аюул, эсвэл туслаач.

Босоо болон налуу малталтаар механикжсан тээврийн үед дараах дохиог хэрэглэнэ:

Нэг дохио – зогс;

Хоёр дохио – дээшээ;

Гурван дохио – доошоо.

4.4. Аврах бүлгийн зүгээс нурлын цаана байгаа осолдогчид өгөх дохио:

Нэг дохио – Нурлын завсраар хоолой (труба) оруул;

Гурван дохио – Хэдэн хүн байна?;

Хоёр+ Хоёр дохио –Агаар өгч эхэллээ.

4.5. Нурлын цаана байгаа осолдогчийн зүгээс аврах бүлэгт өгөх дохио:

Нэг дохио –Хоолой орууллаа;

Хоёр дохио –Хоолой оруулж чадсангүй;

Хоёр+ Хоёр дохио – Бидэнд агаар хүрэлцэхгүй байна;

Гурван дохио – Хүний тоог хэлье, завсар аваад хүний тоогоор дохио

өгнө.

Тав. Аюул ослын үед тусгай мэргэжлийн албадыг зохион байгуулж ажиллуулах

5.1. Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод тохиолдсон олон хоног үргэлжилсэн, хүндэрсэн аюул ослын үед аврах ажлыг шуурхай удирдах, аврагчдын тусгаарлагч шүүгч баг, багаж тоног төхөөрөмжийг цэнэглэх, шалгаж тохируулах, ажилд бэлдэх, шаардлагатай материал, хэрэгслээр хангах, холбоог зохион байгуулах, уурхайн агаарын найрлагыг хянах, инженерийн тооцоо, судалгаагаар хангах зорилгоор Шуурхай удирдлагын төвөөс гадна бусад тусгай мэргэжлийн албадыг байгуулж ажиллана. Үүнд:

5.1.1. газрын гүний удирдлагын төв;

5.1.2. инженерийн алба;

5.1.3. лаборатори;

5.1.4. хангалт үйлчилгээний алба.

5.2. Тусгай мэргэжлийн албадын дарга нар Ослын үеийн удирдагчийн шууд удирдлага дор ажиллана.

Зургаа. Аврах бүлгийн шуурхай ажиллагаа

6.1. Аврах ажиллагааны үед бүлгийн аврагчдын үйл хөдлөлийн харилцан ойлголцолыг сайжруулах зорилгоор аврагчдад (1,2,3,4,5) дугаар олгох ба уурхайд орох, гарах, малталтаар явах, агааргүй орчинд ажиллах болон бусад ажиллагаанд энэ дугаарын дагуу аврагчдын гүйцэтгэх үүргийг тодорхойлно.

6.2. Аюул ослын төрөл, шуурхай ажлын даалгавраас хамаарч аврагчдын биедээ авч явах багаж хэрэгслийн жагсаалтыг гаргасан байна. (4 дүгээр хавсралт)

6.3. Аврах бүлгийн хөдөлгөөнийг дараах дарааллаар зохицуулна:

6.3.1. Ослын голомт руу явахдаа аврах бүлгийн дарга эсвэл ахлах дарга бүлгийг удирдаж цувааны эхэнд явах ба буцахдаа сүүлд нь явна. Хайгуулын ажиллагаа гүйцэтгэж буй үед аврах бүлгийн дарга цоожлогч хоёрын хоорондох зай 8 метрээс илүүгүй байна.

6.4. Эрэн хайх, аврах ажиллагааны үед аврах бүлэг нь газрын гүний удирдлагын төвтэй байнга холбоотой байж нөхцөл байдал, өөрсдийн байрлал, бусад шаардлагатай мэдээллээр хангана.

6.5. Үзэгдэх орчингүй, олон салаа, төвөгтэй малталтуудаар эрэн хайх ажиллагаа гүйцэтгэхдээ салаалсан малталт болон шаардлагатай газруудад чиглэл заасан тэмдэглэгээ үлдээнэ.

6.6. Эрэн хайх, аврах ажиллагаа болон техник ажлуудыг гүйцэтгэх үед Уул уурхайн аврах ангийн бие бүрэлдэхүүнийг уурхайд тусгаарлагч шүүгч баггүй орохыг хориглоно. Аврагчид зөвхөн нэг төрлийн аврах баг хэрэглэнэ.

6.7. Аврагчдын тусгаарлагч шүүгч баг өмсөх газрыг аврах бүлгийн удирдагч тогтоох ба өмсөхийн өмнө багны түргэн шалгалт хийлгэнэ. Шаардлага хангаагүй тусгаарлагч шүүгч багтай ажиллахыг хориглоно. Цэвэр агаартай малталтад аврах бүлгийн удирдагчийн зөвшөөрлөөр тусгаарлагч шүүгч багийг авна. Энэ үед тусгаарлагч шүүгч багийг эзэмшигчээс нь 10 метрээс илүүгүй зайд байрлуулна.

6.8. Аврах бүлэг агааргүй, хорт хийтэй орчинд ажиллагаа гүйцэтгэж буй үед газрын гүний удирдлагын төв дээр бэлтгэл бүлэг байрлана. Зөвхөн хүний амь насыг аврах яаралтай ажлын үед бэлтгэл бүлэггүй ажиллаж болно.

6.9. Аврах бүлэг агааргүй болон өндөр халуунтай орчинд ажиллах тооцоолсон хугацаа дууссан үед газрын гүний удирдлагын төв дээр эргэж ирээгүй, мөн тодорхойгүй шалтгаанаар тэдэнтэй холбоо тасарсан үед газрын гүний удирдлагын төвийн зөвшөөрлөөр бэлтгэл бүлэг нөхцөл байдлыг тодруулахаар араас нь явна.

6.10. Агааргүй, хорт хийтэй орчинд ажил гүйцэтгэхдээ аврах бүлгийн дарга аврагчдыг харагдах, дуут дохио сонсогдохоор газар байлгана.

6.11. Хэрвээ агааргүй, хорт хийтэй малталтаас 5-10 метр зайд цэвэр агаарын урсгалтай малталт байрласан, аврах бүлэг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажил гүйцэтгэх боломжгүй нөхцөлд 2-3 хүний бүрэлдэхүүнтэй бүлгийг агааргүй, хорт хийтэй орчинд ажиллуулахыг зөвшөөрнө. Энэ үед үлдсэн аврагчид ажиллаж буй бүлэгтэй байнгын холбоотой байж аюулгүй байдлыг хангана.

6.12. Агааргүй, хорт хийтэй малталтад тусгаарлагч шүүгч багтай ажиллахдаа хүчилтөрөгчийн баллонд гэнэтийн шаардлагатай тохиолдолд хэрэглэх 5 МПа (50 кг/см^2) хүчилтөрөгч нөөцлөнө. Хэрвээ хүний амь настай холбоотой аврах ажил явуулж байгаа тохиолдолд хүчилтөрөгчийн баллонд байх ёстой нөөцийг 2 МПа (20 кг/см^2) хүртэл бууруулж болно. Тусгаарлагч шүүгч багны хүчилтөрөгчийн баллон дахь нөөцийг (150 МПа) дараах зарчмыг үндэслэн тооцно:

6.12.1. хэвтээ ба 10 градус хүртэлх налуу малталтаар хайгуул хийхэд хүчилтөрөгчийн нөөцийн хагасыг урагшаа явахад үлдсэн хагасыг нь буцахад;

6.12.2. 10 градусаас дээш налуу ба босоо малталтаар хайгуул хийхэд хүчилтөрөгчийн нөөцийн 1/3-ийг урагшаа явахад 2/3-ыг нь буцахад.

6.13. Хүчилтөрөгчийн нөөцийг хамгийн их хүчилтөрөгч зарцуулж байгаа аврагчийн багны манометраар тооцно.

6.14. Үзэгдэх орчин хязгаарлагдмал болон 1 метрээс намхан малталтаар хайгуулын ажиллагаа гүйцэтгэхдээ аврагчид хоорондоо хамгаалах ба чиглүүлэгч олсоор холбогдсон байна. Малталтаар хайгуулын ажиллагаа гүйцэтгэхдээ аврагчид малталтын тэнхлэгт диагинал хэлбэртэй байрлаж урагшилна.

6.15. Хайгуулын явцад аврах бүлгийн замд нэвтэршгүй нурал тааралдвал тухайн орчинд агаарын найрлага, температур хэмжиж, агаарын сорьц авч үүссэн нөхцөл байдлын тухай газрын гүний удирдлагын төвд мэдэгдээд буцна.

6.16. Агааргүй, хорт хийтэй орчинд аврах бүлгийн гишүүдийн хэн нэгний тусгаарлагч шүүгч баганд согог илэрсэн, бие эвгүйцэх ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл бүлгийн даргад мэдэгдэж хайгуулын ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй тохиолдолд бүлгээрээ газрын гүний удирдлагын төв рүү буцна. Аврагчийн бие

гэнэт муудсан, ухаан алдсан тохиолдолдтүүнд яаралтай тусламж үзүүлээд (осолдогчид туслах баг өмсгөнө) орчноос нь агаарын сорьц авч газрын гүний удирдлагын төвд мэдэгдээд бүлгээрээ ойролцоох цэвэр агаарын урсгалтай малталт, удирдлагын төв рүү буцна.

6.17. Агааргүй, хорт хийтэй орчинд осолдогчийг илрүүлээд түүнд анхны тусламж үзүүлж хиймэл амьсгалын аппарат, туслах хүчилтөрөгчийн багаар хангаж газрын гүний удирдлагын төв рүү зөөвөрлөнө. Осолдогчийн дэргэд зөөврийн багажаар агаарын найрлага хэмжиж, сорьц авна.

6.18. Хэрвээ 2 болон түүнээс дээш хүнийг зэрэг зөөх боломжгүй тохиолдолдтусламж үзүүлэхээр бэлтгэл бүлгийг дуудах ба эхний ээлжинд амьсгалтай осолдогчийг зөөвөрлөнө.

6.19. Аврагчид 500 метр, түүнээс хол зайд агааргүй, хорт хийтэй орчинд аврах ажиллагаа гүйцэтгэхдээ нөөц хүчилтөрөгчийн баллон, шүүгч сумтай байна.

6.20. Аврах ажиллагаа дууссаны дараа аврагчид тусгаарлагч шүүгч баг, тоног төхөөрөмжийг цэвэрлэж ариутган дараагийн ажилд бэлтгэнэ.

Долоо. Өндөр халуунтай нөхцөлд аврах ажиллагаа явуулах

7.1. Агаарын температур 27-40 градус (цельс), харьцангуй чийглэг өндөртэй (80 хувиас дээш) нөхцөлд тусгаарлагч шүүгч багтай ажиллахдаа (дулаанаас хамгаалсан тусгай хувцас хэрэглээгүй үед) 5 дугаар хавсралтад заасан хугацаанаас хэтрүүлж болохгүй.

7.2. Агаарын харьцангуй чийглэг өндөртэй, 40 градусаас дээш халуунтай нөхцөлд тусгаарлагч шүүгч багтай уурхайн малталтад хүний амь насыг аврахтай холбоогүй техник ажил гүйцэтгэхийг хориглоно.

7.3. Агаарын харьцангуй чийглэг өндөртэй, 40-50 градусын халуунтай уурхайн малталтад тусгаарлагч шүүгч багтай (дулаанаас хамгаалсан тусгай хувцас хэрэглээгүй үед) хүний амь насыг аврах хойшлуулшгүй ажлын үед бүлгийн тухайн орчинд ажиллах хугацааг 10 минутаас хэтрүүлж болохгүй.

7.4. Аврах ажиллагааны удирдагч агаарын харьцангуй чийглэг, температур өндөртэй нөхцөлд аврах ажиллагаа явуулахдаа чийглэг, градусыг бууруулах, аврагчдыг дулаанаас хамгаалах хувцас хэрэгслээр хангах зэрэг тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.5. Өндөр халуунтай нөхцөлд тусгаарлагч шүүгч багтай ажиллах аврагчид нь биеийн дулааны үйлчлэлийн нөлөөллийн туршилтад орсон байна.

Ажиллагааны үед газрын гүний удирдлагын төвийн эмч, аврагчдын эрүүл мэндийг тогтмол хянана.

7.6. Өндөр халуунтай нөхцөлд ажиллаж байгаа аврах бүлэг ажлын нөхцөл (агаарын температур, чийглэг, агаарын урсгалын хурд, хорт болон тэсрэмтгий хийн агуулга) тэдгээрийн гэнэтийн өөрчлөлтийн тухай газрын гүний удирдлагын төвд байнга мэдээлж байна. Аврах бүлэг хэмжилтийг 5 минут тутам гүйцэтгэнэ.

7.7. Агаарын температур, малталтын налуугаас хамаарч аврах бүлгийн тухайн нөхцөлд хайгуул хийх хугацааг 5 дугаар хавсралтад заасны дагуу тодорхойлно:

7.7.1. хэвтээ ба 10 градус хүртэлх налуу малталтаар хайгуул хийхэд хугацааны хагасыг урагшаа явахад үлдсэн хагасыг нь буцахад;

7.7.2. 10 градусаас дээш налуу ба босоо малталтаар хайгуул хийхэд хугацааны 1/3-ийг урагшаа явахад 2/3-ыг нь буцахад;

7.7.3. хайгуулын явцад цаашлах тутам агаарын температур өсч буй тохиолдолд буцах хугацааг агаарын хамгийн өндөр градустай хугацаагаар тооцно.

7.8. Дараах тохиолдолд аврах бүлэг хайгуулын ажиллагааг зогсоож газрын гүний удирдлагын төв рүү яаралтай буцна:

7.8.1. орчны температур 5 минутын хугацаанд 3 болон түүнээс дээш градусаар нэмэгдсэн тохиолдолд;

7.8.2 5 дугаар хавсралтад заасан зөвшөөрөгдөх хугацаа дууссан тохиолдолд.

7.9. Аврах бүлгийн нэг гишүүний бие муудсан тохиолдолд бүлэг газрын гүний удирдлагын төвд мэдэгдээд бүрэн бүрэлдэхүүнээрээ буцна.

7.10. Аврах бүлэг өндөр халуунтай нөхцөлд ажиллагаа гүйцэтгээд эргэж ажиллах тохиолдолд 2 цагаас багагүй хугацаагаар амарсан байна. Энэ үед эмчийн үзлэгт хамрагдана.

7.11. Хасах градустай нөхцөлд тусгаарлагч, шүүгч багтай ажиллах хугацааг 6 дугаар хавсралтад заасны дагуу тодорхойлно.

7.12. Тусгаарлагч, шүүгч баг, хиймэл амьсгалын аппаратыг хасах градустай нөхцөлд ашиглахын өмнө дараах шаардлагыг хангасан байна:

7.12.1. тусгаарлагч шүүгч багны агаар дамжуулах системийг сайн хатаах;

7.12.2. багны шүүгч шохойг хамгийн бага чийглэгтэй байхаар бэлтгэх;

7.12.3. багны хүчилтөрөгчийн баллоныг хуурайшуулсан хүчилтөрөгчөөр цэнэглэх;

7.12.4. зориулалтын автомашинаар тээвэрлэж, дулаан байранд байлгах.

7.13. Хэрэглэснээс хойш 0 градусаас хасах 5 градусд 15 минутаас илүү, хасах 5 градусаас доош градусд 5 минут ашиглаагүй байлгасан тусгаарлагч шүүгч багийг дахиж хэрэглэхийг хориглоно. Энэ тохиолдолд тусгаарлагч шүүгч багийг дулаан зориулалтын байранд оруулж, хатааж, цэнэглэнэ.

Найм. Газрын дор гал түймэр унтраах

8.1. Уурхайд гал түймэр гарсан үед хүн аврах, аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх ажиллагааг гал түймрийн голомтыг унтраах, тусгаарлах ажилтай нэгэн зэрэг явуулна. Энэ үед шаталтын бүтээгдэхүүн хүмүүст нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангана. Ослын голомтод дуудлагаар нэг бүлэг ажиллаж байгаа тохиолдолд зөвхөн хүний амь насыг аврах ажиллагааг зохион байгуулна.

8.2. Ослын үеийн удирдагч, Уул уурхайн аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар эхний ээлжинд уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу ажиллаж юуны өмнө дараах асуудалд анхаарлаа хандуулна. Үүнд:

8.2.1. шаталтын бүтээгдэхүүн уурхайд байгаа хүмүүсийн бөөгнөрлийг алгасч байхаар уурхайн агааржуулалтын горимыг тооцох;

8.2.2. шаталтын голомтыг тодорхойлж, түүнд ойртох боломжтой бүх арга хэмжээг авах;

8.2.3. шаталтын голомтыг унтраах арга, гал түймэртэй хэсгийг агааржуулах тооцоог хийх;

8.2.4. гал түймэр унтраах, тусгаарлах ажлын хэмжээ, хүн хүчний тооцоо судалгаа гаргах.

8.3. Газрын гүний гал түймрийг унтраахдаа дараах аргыг хэрэглэнэ. Үүнд:

8.3.1. идэвхитэй арга. Гал түймрийн голомтод гал түймэр унтраах хэрэгслээр шууд нөлөөлөх;

8.3.2. тусгаарлах арга. Гал түймрийн голомтод очиж байгаа хүчилтөрөгчийн хэмжээг багасгах, хаах зорилгоор төрөл бүрийн тусгаарлах хаалтууд хийх;

8.3.3. хосолсон арга. Гал түймэртэй хэсгийг түр тусгаарлаад тодорхой хугацааны дараа идэвхитэй арга хэрэглэх.

8.4. Газрын гүний гал түймэр унтраах ажлын үед шаталтын эрчим, уурхайн малталтаар тархах хурдыг бууруулах арга хэмжээг зэрэг авна. Үүнд:

- 8.4.1. шаталтын голомтод очиж байгаа агаарын хэмжээг багасгах;
- 8.4.2. уурхайн малталтад түр хаалт, усан хөшиг, мананцар үүсгэх;
- 8.4.3. агаарын урсгалын чиглэлийг өөрчлөх;
- 8.4.4. дээрх аргуудыг хослон хэрэглэх.

8.5. Газрын гүний уурхайд үүссэн гал түймрийн тархалт, байрлалаас хамаарч аврах бүлгийн шуурхай ажиллагааны даалгавар биелүүлэх чиглэлийг тогтооно.

8.6. Уурхайн босоо ам, шурф, газрын гадаргууд гарцтай бусад малталт, уурхайн дээрх барилга байгууламжид гал түймэр унтраах ажлыг тухайн орон нутгийн Гал унтраах, аврах анги хариуцна. Гал түймэр унтраах үед Уул уурхайн аврах анги, Гал унтраах, аврах ангийн харилцан ажиллагааг “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу зохион байгуулна.

8.7. Уурхайд гал түймэр унтраах үед дараах агааржуулалтын горимыг хэрэглэнэ:

- 8.7.1. шатаж байгаа малталтын агааржуулалтыг зогсоох;
- 8.7.2. гал түймэр гарахаас өмнө байсан агааржуулалтын горимыг хэвээр нь хадгалах;
- 8.7.3. гал түймрийн голомтод очиж байгаа агаарын урсгалын хэмжээг нэмэх, хасах;
- 8.7.4. агаарын урсгалын чиглэлийг өөрчлөх.

8.8. Агааржуулалтын горимыг сонгохдоо тухайн уурхайн хийн болон тоосны тэсрэлтийн аюулын зэрэглэлийг харгалзана. Аюулын бүсээс хүмүүсийг бүрэн гүйцэд гаргаагүй үед агааржуулалтын горимыг өөрчлөхийг хориглоно.

8.9. Уурхайн агааржуулалтын босоо ам, босоо ам орчмын малталт, түүнтэй холбогдсон агааржуулалтын төв малталтад гал түймэр, тэсрэлт гарсан тохиолдолд уурхайн агаарын урсгалын чиглэлийг өөрчлөх нь үр дүнтэй.

8.10. Газрын гүний гал түймэр унтраах ажлын үед шатамхай хий (метан, нүүрсхүчлийн дутуу исэл, устөрөгч болон бусад), хүчилтөрөгчийн найрлага, агаарын урсгалын хурд, температурыг тасралтгүй хянаж, хэмжинэ. Хийн аюултай уурхайд гал түймрийн голомт руу очиж байгаа агаарын урсгал дахь метаны хэмжээг байнга тооцно. Метаны хэмжээ 2 хувь хүрсэн тохиолдолд ажлыг зогсоож аврагчдыг аюулгүй газарт нэн даруй шилжүүлнэ.

8.11. Өндөр градустай нөхцөлд уурхайн малталтад тусгаарлах хаалт хийхдээ эхлээд түр хаалт босгож халууны үйлчлэлийг бууруулсны дараа байнгын хаалтыг хийнэ.

8.12. Үл мэдэгдэх шалтгаанаар агаарын урсгалын чиглэл өөрчлөгдсөн тохиолдолд газрын гүний удирдлагын төвд мэдэгдээд аврагчид аюулгүй газарт очиж шалтгааныг тодруулах хүртэл хүлээнэ.

8.13. Хэрвээ гал түймрийн нөхцөл байдал хүндэрч метаны хэмжээ үргэлжлэн өсч байгаа тохиолдолд аврагчдыг яаралтай аюулгүй газарт гаргаж хийгүйжүүлэх арга хэмжээг авах ба цаашилбал аюулгүй зайд байнгын бин битүү хаалт хийх эсхүл малталтыг усанд автуулна. Хаалт нь тэсрэлтийн цохих долгионыг барих чадвартай байна.

Ес. Аврах ажиллагааны үед Уул уурхайн аврах ангийн албан хаагчийн үүрэг

9.1. Уул уурхайн аврах ангийн албан хаагчид нь “Эрэн хайх аврах ажиллагааны нийтлэг журам”-д заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна дараах үүрэг хүлээнэ.

9.1.1. аврагч-баг эзэмшигч

а. Өөрийн бүлгийн шуурхай ажиллагааны даалгавар, түүнийг биелүүлэх арга замыг мэдсэн, уурхайд газрын гүний удирдлагын төвийн байрлал, туулж өнгөрсөн замаа тогтоох;

б. Осолдогчдод яаралтай тусламж үзүүлэх, уурхайн аврах тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх;

в. Ажлын байрны аюул үүсч болзошгүй нөхцөл, аврагчдын аюулгүй байдалд байнга хяналт тавих;

г. Тусгаарлагч шүүгч багийг өмсөх, тайлах ажиллагааг зөвхөн бүлгийн даргын тушаалаар гүйцэтгэнэ. Агааргүй орчинд тусгаарлагч шүүгч багны баллон дахь хүчилтөрөгчийн нөөцийг байнга хянах ба зуултны гадуур ярихыг хориглоно;

д. Ажлын байранд илэрсэн аюулын талаар болон тусгаарлагч шүүгч баганд гэмтэл гарсан, биеийн эрүүл мэнд муудсан тохиолдолд бүлгийн аврагчид яаралтай мэдэгдэх;

е. Ажиллагаа гүйцэтгэсний дараа өөрийн тусгаарлагч шүүгч баг, багаж, тоног төхөөрөмжийг шалган дараагийн ажиллагаанд бэлдэх.

9.1.2. бүлгийн цоожлогч

а. Бүлгийн хамгийн туршлагатай аврагч-баг эзэмшигч байх ба шаардлагатай тохиолдолд бүлгийн даргыг орлож ажиллана. Бүлэг хайгуулын ажиллагаа гүйцэтгэж буй үед сүүлд нь явах ба аврагчдын биеийн эрүүл мэнд, орчны нөхцөл

байдалд хяналт тавьж бүлгийн даргын дохиог давтана. Газрын гүний удирдлагын төв рүү болон уурхайгаас гарах үед түрүүнд нь явна.

9.1.3 бүлгийн дарга

а. Бүлэгт өгөгдсөн шуурхай ажиллагааны даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулах, явах зам, аврах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг мэдэх;

б. Даалгавар гүйцэтгэхээр орохын өмнө аврагчдад бүлгийн шуурхай ажиллагааны даалгавар, түүнийг биелүүлэх арга замыг танилцуулж, аврагчдынтусгаарлагч шүүгч баг, ашиглах багаж тоног төхөөрөмжийг шалгаж бэлдүүлэх;

в. Тусгаарлагч шүүгч багийг зөв өмсөж байгаа эсэх, бүлгийн аврагчдын биеийн байдал, аврагчдын тусгаарлагч шүүгч багны хүчилтөрөгчийн зарцуулалт, өндөр хэмтэй нөхцөлд ажил гүйцэтгэх, буцах зөвшөөрөгдөх хугацаанд хяналт тавих;

г. Нэрвэгдэгчийг илрүүлсэн үед түүнд анхны тусламж үзүүлэх, туслах хүчилтөрөгчийн баг өмсгөх, аюулгүй орчинд зөөвөрлөх ажлыг зохион байгуулах;

д. Бүлгийн аврагчдын нэг гишүүний бие муудсан, тусгаарлагч шүүгч баганд гэмтэл гарсан тохиолдолд бүлгийг газрын гүний удирдлагын төв, цэвэр агаартай газарт аваачих;

е. Газрын гүний удирдлагын төвд аюул, ослын нөхцөл байдал, бүлгийн үйл ажиллагаа, өгөгдсөн даалгаврын биелэлтийн талаар байнга мэдээлэх;

ё. Ажил гүйцэтгэсний дараа аврах ажиллагааны ерөнхий удирдагчид үүссэн нөхцөл байдал, даалгаврын биелэлтийн талаар илтгэх;

ж. Аврах бүлгийн бэлэн байдлыг хангах.

9.1.4. салбарын захирагч

а. Үүссэн нөхцөл байдал, тухайн аж ахуйн нэгжийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”, аврах шуурхай ажиллагааны төлөвлөгөө, план зураг, орц гарцын схем, бусад шаардлагатай материалтай танилцсан байх;

б. Нөхцөл байдалтай уялдуулан аврах бүлгүүдийн ажил, амралтын горим, хуваарийг тогтоох;

в. Аврах ажиллагааг ажлын байран дээр нь шууд удирдах ба аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аврагчдын аюулгүй байдлыг хангах;

г. “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”, шуурхай ажиллагааны даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулах, аврагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

д. Газрын дээрх удирдлагын төвд аюул ослын нөхцөл байдал, өгөгдсөн даалгаврын биелэлт, шаардлагатай арга хэмжээний талаар цаг алдалгүй мэдээлэх;

е. Аврах салбарын бэлэн байдлыг хангах.

9.1.5. ерөнхий инженер

а. Уурхай, уулын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилт, ажлын явц, тухайн үүссэн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, газрын гүний удирдлагын төвд аврах ажиллагааг шууд удирдах;

б. Аюул ослын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, аврах ажлыг аюулгүй гүйцэтгэх, шийдвэр гаргахад шаардлагатай инженерийн тооцоо, зураглалыг хийх;

в. Аврах ажиллагаа явуулахад шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн тооцоо, судалгааг гаргах;

г. Аврах ажиллагааны ерөнхий удирдагчид аюул ослын үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар цаг алдалгүй мэдээлэх.

9.1.6. эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч

а. Эрэн хайх аврах ажиллагааны удирдагч, салбарын захирагч, болон бусад удирдах бүрэлдэхүүний үйл ажиллагааг хянаж, зөвлөх ба шаардлагатай тохиолдолд аврах ажиллагааг удирдана;

б. Үүссэн нөхцөл байдалд (агааржуулалт, шатамхай хийн агуулга, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлж байгаа байдал) болон гүйцэтгэж байгаа аврах ажиллагааны үр нөлөөнд дүн шинжилгээ хийх;

в. Шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад оролцох;

г. Аврах ажиллагааны нөхцөл байдалтай газар дээр нь танилцах;

Тайлбар.

Үйлдвэрлэлийн аюултай объект* - Ил далд уурхай, уулын баяжуулах, боловсруулах үйлдвэр, дулааны болон дулааны цахилгаан станц, төмөрлөгийн үйлдвэр, химийн үйлдвэр зэрэг хүнд үйлдвэрүүд орно.

ОСЛЫН ДУУДЛАГЫН ХУУДАС
ДУГААР...

Дуудлага өгсөн уурхай, аж ахуйн нэгж

нэр.....

.....

.....

Байршил.....

.....

.....

Аюул ослын төрөл.....

.....

Аюул осол үүссэн газар

.....

.....

Дуудлага өгсөн өдөр, цаг, минут.....

Дуудлага өгсөн хүний овог, нэр

Харилцах утас

Дуудлага хүлээн авсан.....

ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ

Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр

Аюул ослын төрөл

Аюул осол үүссэн газар

Аюул осол үүссэн хугацаа

Аюул ослын нөхцөл байдалцагмин

УУАА-ийн даалгавар

Хүмүүсийг аюулгүй газарт гаргах

Осолдогчдод тусламж үзүүлэх

Хор уршгийг арилгах ажиллагаа

Ослын үеийн

удирдагчцагмин

Гарын үсэг Нэр

| Өдөр, цаг, мин | Шуурхай ажиллагааны даалгаврын агуулга, нөхцөл байдлын өөрчлөлт, хор уршгийг арилгах ажлын явц | Гүйцэтгэгчийн нэр, гарын үсэг, даалгавар биелүүлсэн тухай тэмдэглэл, цаг, мин |
|----------------|--|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ №

Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр

Аюул осол үүссэн хугацаа

Төлөвлөгөө боловсруулсанонсарөдөрцагмин

Аюул ослын нөхцөл байдалцагмин

.....

| д/д | Авах арга хэмжээ | Биелүүлэх хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|-----|------------------|-------------------|--------------------------|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Ослын үеийн
 удирдагч

Гарын үсэг Нэр

Аврах ажиллагааны ерөнхий
 удирдагч

Гарын үсэг Нэр

**БҮЛГИЙН АВРАГЧДЫН БИЕДЭЭ НЭМЭЛТЭЭР АВЧ ЯВАХ БАГАЖ,
ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

| Бүлгийн дарга | Аврагч- баг эзэмшигч | | | |
|---|---|---|---|---------------------------|
| | № 1 | № 2 | № 3 | № 4 |
| Агааргүй орчинд хайгуул хийх, хүмүүсийг аврах ажиллагааны үед | | | | |
| Бүлгийн даргын цүнх, зөөврийн хий тодорхойлогч, мэдрэгч | Дамартай утастай холбооны хэрэгсэл | Туслах тусгаарлагч шүүгч баг Р-34 | Хиймэл амьсгалын аппарат, дамнуурга, бүтээлэг | Эмнэлгийн цүнх, дамнуурга |
| Газрын гүний удирдлагын төв дээр байгаа бэлтгэл бүлэг | | | | |
| Бүлгийн даргын цүнх, зөөврийн хий тодорхойлогч, мэдрэгч | Завсрын холболттой холбооны хэрэгсэл, туслах баг Р-34 | Туслах тусгаарлагч шүүгч баг Р-34, хиймэл амьсгалын аппарат | Хиймэл амьсгалын аппарат, дамнуурга, бүтээлэг | Эмнэлгийн цүнх, дамнуурга |
| Нурлын үеийн аврах ажиллагаанд | | | | |
| Бүлгийн даргын цүнх, зөөврийн хий тодорхойлогч, мэдрэгч | Аврах багажны цуглуулга, хүрз | Дамнуурга, бүтээлэг | Хиймэл амьсгалын аппарат, дамнуурга | Эмнэлгийн цүнх |

Тайлбар:

1. Газрын гүний удирдлагын төв дээр аврах ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, тусгаарлагч шүүгч багны нөөц хүчилтөрөгчийн баллон, шүүгч сум байлгана.

2. Аврагчдын амьсгалын эрхтэнийг хамгаалах хэрэгсэл нь бүрэн тусгаарлах зориулалтын хийцтэй байна.

3. Аврах бүлэг хайгуулын ажиллагаа зохион байгуулж байгаа үед газрын гүний удирдлагын төв дээр эмч байна.

ӨНДӨР ХАЛУУНТАЙ НӨХЦӨЛД, ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧИНД АВРАГЧДЫН
ТУСГААРЛАГЧ ШҮҮГЧ БАГТАЙ АЖИЛЛАХ ДЭЭД ХУГАЦАА

| Агаарын температур(°C) | Нэг газарт ажиллах үед (минутаар) | Хайгуулын ажлын үед (минутаар) |
|------------------------|--------------------------------------|-----------------------------------|
| 27 | 210 | 158 |
| 28 | 180 | 135 |
| 29 | 150 | 113 |
| 30 | 120 | 90 |
| 31 | 90 | 68 |
| 32 | 60 | 45 |
| 33 | 50 | 38 |
| 34 | 40 | 30 |
| 35 | 34 | 26 |
| 36 | 30 | 23 |
| 37 | 26 | 20 |
| 38 | 22 | 17 |
| 39 | 20 | 15 |
| 40 | 18 | 14 |

Тайлбар: Дулаанаас хамгаалсан тусгай хувцас, хэрэгсэл хэрэглээгүй үе

УУЛ УУРХАЙН АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

| № | Тэмдэглэгээ | Тайлбар |
|----|---|--|
| 1 |  | Агаарын урсгалын чиглэл |
| 2 |  | Агааржуулалт |
| 3 |  | Усанд автсан газар |
| 4 |  | Утаатай газар |
| 5 |  | Галыг илрүүлсэн газар |
| 6 |  | Гал эсэргүүцэх болон даралтат хийн хоолой |
| 7 |  | Байнгын битүү хаалт |
| 8 |  | Агааржуулалтын хаалганууд. Хаалга хаалттай |
| 9 |  | Агаарын урсгалыг тохируулах хаалт |
| 10 |  | Эвдэрсэн эсвэл онгорхой байнгын хаалт |
| 11 |  | Амьд осолдогч |
| 12 |  | Цогцос |
| 13 |  | Таазны тулгуур хийсэн модон бэхэлгээ |
| 14 |  | Уурхайн малталтан дахь нурлын зах |
| 15 |  | Уурхайд агаарын найрлага хэмжсэн газар |
| 16 | $CO = x \text{ ppm}$ $CH_4 = y \%$ $O_2 = z \%$ $CO_2 = v \%$ | Хийн хэмжилтийн үр дүнгийн бичиглэл. Жич: хэмжилтийн дугаарыг бичээд хэмжилтийн үр дүнг хажууд нь бичнэ. |
| 17 |  | Тодорхойгүй зүйл, тоног төхөөрөмж |
| 18 |  | Агаарын хоолой |
| 19 |  | Уулын цулыг зөөвөрлөх конвейер |
| 20 | BC  | Түр хаалтны материал |

| | | |
|----|-----|---|
| 21 | LC | Агаарын хөшиг хийх материал |
| 22 | OFF | Малталтанд байсан зүйлийг авсан |
| 23 | ON | Малталтанд шинээр юм хийсэн, эсвэл сэргээн босгосон |
| 24 | 1 | 15 минут тутам багны түргэн шалгалт хийсэн газар |
| 25 | GGO | Инертийн хийн генератор |
| 26 | P | Насос |

---oOo---